

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК – НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Тус компани нь Баян-Өлгий аймгийн төв бүх айл өрх, албан байгууллагуудад дулааны эрчим хүч үйлдвэрлэж түгээдэг.

2022 онд 112 хүний бүрэлдэхүүнтэйгээр эрчим хүчний зохицуулах хорооноос авсан дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

Тус компаниас худалдан борлуулах дулааны эрчим хүчний үнэ тарифыг Эрчим хүчний зохицуулах хорооноос 2021 оны 10 сарын 14 өдрийн 466 тоот тогтоолын дагуу мөрдөж ажиллаж байна.

Дээрх тогтоолын хавсралтад зааснаар дулааныг нэмэгдсэн өртгийн албан татваргүйгээр албан байгууллагуудад 1600, орон сууцанд амьдардаг айл өрхүүдэд 800 төгрөг, ААНэгжүүд 1200 төгрөгөөр борлуулж байна.

Тус бүр 13Гкал/цаг – ийн хүчин чадалтай КЕ25-14 маркийн 3 зуух болон 20 Гкал/цаг - ийн хүчин чадалтай КВТС-20-150 маркийн 1 зуухтайгаар ажиллаж байна. КЕ25-14 нэг зуухыг тоног төхөөрөмжийг шинэчилж 2021 оны 01 сард ашиглалтанд оруулав. Үлдсэн 3 зуухаар өлгийн горим ажиллагааг хэвийн хангав.

Нийт 1843 хэрэглэгчээс айл өрх 1333, хувийн амины орон сууц 221, төсөвт байгууллага 48, аж ахуйн нэгж 241 байна.

Тайлант хугацаанд 33,837,324 төгрөгийн цэвэр ашигтай гарсан боловч 1,521,625,349 төгрөгийн дансны өглөгтэй, татварын албанд төлөх 478,031,892 төгрөгийн, НДШ-ийн өглөг 91,739,336 төгрөг,

банкнаас авсан богино хугацааны 1,044,482,252 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, урт хугацаат зээл 1,592,218,632 төгрөг байна.

2022 оны 3-р улиралын байдлаар мөнгөн хөрөнгө 179,851,988 дансны авлага 1,796,995,047 бусад авлага 470,559,138 бараа материал 473,784,395 урьдчилж төлсөн орлого 291,482,524 эргэлтийн хөрөнгийн нийт дүн 3,212,673,092 төгрөг байна.

Үндсэн хөрөнгө 5,622,854,110 биет бус хөрөнгө 103,219,560 эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн 5,726,073,670 нийт хөрөнгийн дүн 8,938,746,762 төгрөг байна.

Мөнгөн зарлагын дүн 2,087,828,741 төгрөг байгаагаас ажилчидад олгосон мөнгөн зарлага 431,530,854 нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө 85,867,968 бараа материал худалдан авахад төлсөн мөнгө 271,384,488 ашиглалтын зардалд төлсөн мөнгө 209,398,635 түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгслийн үнэд 512,208,520 хүүд төлсөн 257,472,989 татварын байгууллагад 316,719,752 төгрөг, даатгалын төлбөрт 3,245,535 төгрөг тус тус төлсөн байна.

Компанийн 2022 оны 3-р улиралын санхүүгийн тайланг 2022 оны 09 сарын 30 – ний өдрөөр тасалбар болгон гаргаж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ЕРӨНХИЙ НЯ-БО



М. ТИЛЕУБЕРДИ

К. ЕРБОЛАТ